



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/331

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ховд хот" сүлд дууны хөшөө босгох /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгч "Арлын ам" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Цогтбаяр – Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Б.Отгонхишиг – Аймгийн Хөгжимт драмын театрын ерөнхий найруулагч

Б.Сүхбаатар – Музейн бүртгэл мэдээллийн санч

Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Г.Жавзанхорлоо – Нийгмийн бодлогын хэлтсийн соёл урлаг, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. "Ховд хот" сүлд дууны хөшөө босгох /Жаргалант сум/ ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Цогтбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/331 Ch
02 01452